



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/538

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Цагдаагийн газрын Бичигт, Алагтолгой багуудын хэсгийн кубоны байрны Цахилгаан халаалтанд холбох ажил”-д зориулан 10 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 10 000 000 төгрөг /арван сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 5.36-д тусгагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ

Zax A/538 Ch

02 02398